GOBI
MONGOLIAN CASHMERE

# "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

***2015*** оны ***06*** сарын ***26*** өдөр Дугаар ***01*** Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН нь:

"Говь" ХК-ийн ээлжит бус хурал нь 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагаас болов. Хурлын бүрэлдэхүүнд ТУЗ-ийн дарга Д.Хүрэлбаатар хурлын даргалагчаар оролцон, ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа, Т.Одмаа, Такеши Камбэ болон Д.Хулан нар оролцов. Тооллогын комиссын дарга Д.Тэгшжаргал хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц 85.7 хувьтай хурлын ирц компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх зүйлд заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг зөвшөөрөв. Хурал 10 цаг 3 минутад эхлэв.

Хэлэлцсэн асуудал:

1. ***Компанийн дүрэмд гарах өөрчлөлтийн тухай***

СОНССОН нь:

Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр:

- ТУЗ-ийн гишүүдийг сонгоход ердийн болон кумулятив аргыг хэрэглэн сонгон шалгаруулалтыг хийдэг. Үүнээс нээлттэй хувьцаат компани кумулятив аргыг хэрэглэх нь цаашид илүү тохиромжтой гэж үзэн дүрмэндээ өөрчлөлт оруулахаар саналаа оруулж байна. Компанийн тухай хуулийн 77.4-т ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо энэ аргыг хэрэглэхийг заасан байгаа.

ТУЗ-ийн дарга Д.Хүрэлбаатар:

- Энэ аргаар санал өгөх тухай хуудасны доор дэлгэрэнгүй тайлбарлан бичсэн байгаа.

Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр:

- Ердийн аргаар санал хураахад 1 саналын эрхээр 1 саналыг өгдөг, кумулятив аргаар тухайн хувьцаа эзэмшигч нь өөрийн хувьцааны тоогоор санал өгөх гишүүдийн тоог үржүүлж гарсан дүнг санал өгөх гишүүдэд хувааж тавьдаг арга юм. Саналын хуудас дээр ердийн гишүүн 5, хараат бус гишүүнд 4 гишүүн нэр дэвшсэн байгаа. Компанийн тухай хуулиар бол хараат бус гишүүн нь 1/3-ээс доошгүй байна гэж заасан байгаа. Жишээ нь: 100ш саналын хувьцаатай бол 9 гишүүний тоогоор үржүүлж 900 саналын эрхийг хуваах өгнө. Ердийн гишүүнд 500 саналыг, хараат бус гишүүнд 400 саналыг хуваарилж өгнө. Санал хураалтыг ердийн болон кумулятив аргаар тус тусад нь тооцно.

2. ***ТУЗ-ийн гишүүдийг сонгож батламжлах тухай***

СОНССОН нь:

GOBI
MONGOLIAN CASHMERE

ТУЗ-ийн дарга Д.Хүрэлбаатар:

- Брокер диллерийн компаниар ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн хүмүүсийн тухай мэдээллийг хүргэгдсэн байгаа. Мөн ээлжит хурлаар танилцуулж байсан. 1 гишүүний санал хүрээгүй тул дахин ээлжит бус хурлыг хийхээр болсон. (Нийт сонгогдох гишүүдийн танилцуулгыг дэлгэцээр танилцуулав) Гишүүдийн талаар асууж тодруулах зүйл байна уу? (Хуралд хүрэлцэн ирсэн хүмүүсээс санал хүсэлтийг асуухад хариу өгсөнгүй тул тооллогын комиссын дүнг бэлтгэх хооронд танилцуулга видео бичлэгийг үзүүлсэн.)

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг баталсугай.
2. "Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Д. Хүрэлбаатар /УХ61111512/
2. Такеши Камбэ /TF7995260/
3. Т.Одмаа /ХА76010801/
4. Д.Гэрэлмаа /УХ65042803/ нарыг;

"Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

5. Ц. Баатарсайхан /ПБ66011274/
6. Д.Хулан /ХП68082200/
7. Хидео Савада /TG5384200/
8. Д. Наранбаатар /ЦД82062574/
9. Ц. Отгонбаатар /ПБ75100216/ нарыг тус тус сонгосныг батламжилсугай.

Хурал 10 цаг 46 минутанд өндөрлөв.

Хурлын даргалагч: ТУЗ-ийн дарга Д.Хүрэлбаатар

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-НБД Б.Мөнхцэцэг

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

GOBI
MONGOLIAN CASHMERE

# ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 26 өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. ГОВЬ ХК-ийн дүрэмд оруулах өөрчлөлтийг Төлөөлөн Удирдах зөвлөлөөс оруулсан компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг Хавсралт №1-ээр баталсугай.
2. Компанийн дүрэмд оруулсан дүрмийн шинэчилсэн найруулгын бүрэн эхийг Хавсралт №2-оор баталсугай.

Компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д үүрэг болгосугай.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ УЖМ0034 1076357

ХУРЛЫН ДАРГА Д.ХҮРЭЛБААТАР

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2015 оны 06-р сарын 26-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт№1

## Компанийн дүрэмд орсон өөрчлөлтүүд

| д/д | Өөрчлөлт орсон дүрмийн заалт | Урьдны дүрмийн заалт | Шинээр өөрчлөгдсөн заалт |
|---|---|---|---|
| 1 | 7-7.1 | ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал ердийн аргыг хэрэглэнэ. | ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. |

GOBI

MONGOLIAN CASHMERE

# ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 06 сарын 26 өдөр　　　　Дугаар 06　　　　Улаанбаатар хот

## Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.8 дахь заалт, Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

***Нэг.*** "Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Д.Хүрэлбаатар /УХ61111512/
2. Такеши Камбэ /TF7995260/
3. Т.Одмаа /ХА76010801/
4. Д.Гэрэлмаа /УХ65042803/ нарыг;

***Хоёр.*** "Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

5. Ц.Баатарсайхан /ПБ66011274/
6. Д.Хулан /ХП68082200/
7. Хидео Савада /TG5384200/
8. Д.Наранбаатар /ЦД82062574/
9. Ц.Отгонбаатар /ПБ75100216/ нарыг тус тус сонгосныг батламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА　　　　　　Д.ХҮРЭЛБААТАР

GOBI MONGOLIAN CASHMERE

# ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

2015 оны 6 сарын 26-ны өдө

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦ

Хуудас

| № | Хувьцаа эзэмшигчийн овог | Хувьцаа эзэмшигчийн нэр | Регистрийн дугаар | Эзэмшиж буй хувьцааны тоо | Дансны дугаар | Брокерийн пүүсийн нэр |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Фронтиер | HIDE INTER LLC | 0110-02-026755 | 2,652,383 | 19 = 23'871'447ш | |
| 2 | Ханшинвест | ЭФ-СИ-АЙ ХХК | PE-901902802 | 2,230,019 | | |
| 3 | Бидисек | ТАВАНБОГДТРЕЙД ХХК | 2543303 | 1,239,796 | | |
| 4 | Бидисек | ҮЛЭМЖИХ ХХК | 2643774 | 438,829 | | |
| 5 | Дашдаваа | ХУЛАН | ХП68082200 | 122,473 | | |
| 6 | Цагаач | БААТАРСАЙХАН | ПБ66011274 | 500 | | |
| 7 | ДАМБИЙЖАВ | ХҮРЭЛБААТАР | УХ61111512 | 48 | | |
| 8 | Сүх | Баатарсүрэн | ХЕ58110812 | 500 | | Зэргэд |
| 9 | | | | | | |
| 10 | | | | | | |
| 11 | | | | | | |
| 12 | | | | | | |
| 13 | | | | | | |
| 14 | | | | | | |
| 15 | | | | | | |
| 16 | | | | | | |
| 17 | | | | | | |
| 18 | | | | | | |
| 19 | | | | | | |
| 20 | | | | | | |
| 21 | | | | | | |

Тооллогын комиссын дарга — Д.Тэгшжаргал
Нарийн бичгийн дарга — С.Цэрэнчимэд
Гишүүд — Г.Золзаяа
З.Цэрэнпүрэв

ЭФ СИ АЙ

ГАДААД ХУДАЛДАА

2015.06.25 № 16/10

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 7-р хороо
15-хороолол, Хаан палас 615 тоот
Утас: 99118002, Факс: 345223

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Итгэмжлэл олгох тухай

Говь хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд "Эф Си Ай" ХХК /РД:РЕ901902802/-ийн эзэмшиж буй нийт 2,230,019 ширхэг хувьцааг төлөөлөн оролцож, хэлэлцэж буй асуудлаар санал өгөх эрхийг Монгол улсын иргэн ХП68082200 регистрийн дугаартай, Дашдаваа овогтой Хуланд итгэмжлэн олгов.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ХУЛАН

FCI LLC ЭФ СИ АЙ ХХК УЛААНБААТАР ХОТ ТТА7107 № 5143287

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

“Үлэмж Их” ХХК
Смарт худалдааны төв
Баянгол дүүрэг, 19-р хороо,4 хороолол
Улаанбаатар 210136, Монгол Улс
Утас: 355455, Факс: 364492

2015.06.25 № 11/04

Танай__________-ны №_____________-т

Итгэмжлэл олгох тухай

“Говь” хувьцаат компанийн 2015 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал “Үлэмж Их” ХХК-ийн эзэмшиж буй 5.63%-ийн саналын эрхтэй, нийт 438,829 ширхэг хувьцааг төлөөлөн оролцож, хэлэлцэж буй асуудлаар санал өгөх эрхийг Монгол улсын иргэн ХП68082200 регистрийн дугаартай Дашдаваа овогтой Хуланд итгэмжлэн олгов.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ДАВААЖАВ

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД


**ТАВАН БОГД ТРЕЙД ХХК**

Таван Богд Төв байр,
Хан-Уул дүүрэг Чингисийн өргөн чөлөө,
Улаанбаатар 210136, Монгол Улс
Утас: 976-11-345225, Факс: 976-11-345223
Электрон шуудан: info@tavanbogd.com
Вэб хуудас: www.tavanbogd.com


2015 · 06 · 25 № 01/395

танай -ны № -т

Итгэмжлэл олгох тухай

Говь хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд “Таван богд Трейд” ХХК /РД: 2543303 /-ийн эзэмшиж буй нийт 1,239,769 ширхэг хувьцааг төлөөлөн оролцож, хэлэлцэж буй асуудлаар санал өгөх эрхийг Монгол улсын иргэн ПБ66011274 регистрийн дугаартай, Цагаач овогтой Баатарсайханд итгэмжлэн олгов.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Ц.БААТАРСАЙХАН

бямба гаригт нэрэмжит тэмцээнээ зохион байгуулав. Эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан болон хосын төрөлд нийт 50 орчим тамирчин өрсөлдсөн юм. Хосын төрөлд өрсөлдөж буй тамирчид эхлээд гурван тоглолт хийв. Үүнээс эхний найман баг тунаж, оноогоороо нэгд шалгарсан нь наймд шалгарсан багтайгаа халз тоглож, хасагдах журмаар аваргаа тодруулсан юм. Ганцаарчилсан төрлийн тэмцээн ч энэ мэтээр хасагдах журмаар өрсөлдөж, шилдгүүдээ шалгаруулсан. Эрэгтэй ганцаарчилсан төрөлд Б.Пүрэвдорж, М.Түвшинсанаа, Ж.Содномдорж нар эхний гурван байрт шалгарсан бол эмэгтэйчүүдээс С.Дэлгэрцэцэг, Майнгэгэн, М.Долгормаа нар бусдыгаа манлайлав. Тэгвэл хосын төрөлд Г.Магсаржалам, С.Дэлгэрцэцэг нар түрүүллээ. Харин хоёрдугаарт Ц.Лхаасүрэн, Э.Бат-Орших, гуравдугаар байранд В.Энхбат, С.Бямбасүрэн нар шалгарлаа. Ц.Лхаасүрэн нийт 236 авч, шилдгийн шилдэг тоглогч болов.

МӨНХ

Энэ онд улсын хэмжээгээр нийт .200 га талбайд тариалалт хийх илт дэвшүүлсэн тариаланчид ан буудайгаа тарьж дуусчээ. огоор 337.000 га-д үр тариа, ээс 322.200 га-д улаан буудай, 0 га-д төмс, 3700 га-д хүнсний оо, 7.300 га-д малын тэжээл, 600 га-д тосны ургамал, нийт .500 га-д тариалалт хийгээд гаа аж. Үр тарианы тариалалт 102.5 хувьтай байгаа бөгөөд Булган, Хөвсгөл, Орхон, Хэнтий, Дархан-Уул, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Дорнод аймгууд улаан буудайг төлөвлөсөн хэмжээнээс давуулан тарьсан юм байна. Тэгвэл төмс, хүнсний ногооных 43.1-62.5 хувьтай байгаа аж. Ажлын явцыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тариа 13.7 хувь илүү, төмсний тариалалт өмнөх оны түвшинд, хүнсний ногооных 3.2 хувиар бага байгаа юм байна.



гоминдааны дээрэмч удаа тулгаран байлд Түүнийг нөхдийнх нь ийн 1949 оны нэгдү 28-нд "Байлдааны гав тугийн одон"-гоор наж, алба хааж ба Байтагийг түүни болгосон байна.

АИХТ-ийн аравдугаар сар өдрийн 200 дугаа Б.Гиваанд Мон баатар цол нэхэн олгожээ. Албаа хаасан хилчдээ нэгэн үе Б.Гиваан цалин олгодог байсан гэдэг.


GOBI

MONGOLIAN CASHMERE

"Говь" хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагт "Говь" ХК-ийн хурлын танхимд болно. Бүртгэх өдөр 2015 оны 2 дугаар сарын 28-ны өдөр. Хувьцаа эзэмшигч та бүхэн 5 дугаар сарын 23-ны өдрөөс брокер дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцана уу.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдэд 09.30-17.00 цагийн хооронд "Говь" ХК-ийн төв байранд ирж Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргатай уулзан танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс харилцдаг брокер, диллерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер, диллерийн компанидаа эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2015 оны 6 сарын 22-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**Холбоо барих утас:**
343051 (1226), 9811 8891
**И-мэйл:** tsaschikher@gobi.mn

**"Говь" ХК-ийн албан ёсны хаяг, байршил:**
Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг,
3-р хороо, Үйлдвэрийн гудамж, "Говь" ХК
**Утас:** 3413051, **Факс:** 343081



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН 2015 ОНЫ БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ ОРОН ДАЯАР ЯВАГДА

**Төгсгөл. Түрүүч нь А1 нүүрт**

Элсэлт орон даяар, цахим хэлбэрээр 2015 оны дөрөвдүгээр сарын 27-ноос зургадугаар сарын 3 хүртэл явагдах бөгөөд элсэлтийн журам болон бүртгэлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг **http://** **edu.mn** болон **http://www.num.edu.mn** цахим хуудаснаас аваарай.




**Энэ жилийн элсэлтийн онцлог:**

- МУИС элсэлтийн системээрээ **(http://burtgel.num.edu.mn)** орон даяар, цахим хэлбэрээр элсэлтээ авах тул МИДСК (Монголын их дээд сургуулийн консорциум)-аар МУИС-ийн хувиар орон нутагт очихгүй.
- Манай элсэлтийн бүртгэл ЭЕШ (Элсэлтийн ерөнхий шалгалт)-ын дүн гарахаас өмнө хийгдэж байгаа бөгөөд Боловсролын үнэлгээний төвөөс ЭЕШ-ын оноо гармагц бүртгүүлэгч шалгалт өгсөн хот, аймагтаа оноогоороо жагсан, хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчид элсэх эрх олгоно.
- Бүртгүүлэгч таны өгсөн элсэлтийн ерөнхий шалгалтаас "Суурь" шалгалтад нэг хичээл, "Дагалдах" хичээлийг тооцно. Мөн "Суурь" шалгалтад тооцуулсан хичээлийг "Дагалдах" шалгалтад тооцуулах болом үү.

Бүрэлдэхүүн сургуулиудын хөтөлбөрүүдтэй **http://burtgel.num.edu.mn** болон **http://www.num.** хуудсаар танилцаарай.

...н удаа өөрчлөлт
уд хэлэх юм бол
йн Засаг даргын
ілсэн орлогч дарга
шалтгаантай нь
үй даргадаад их
іэ асуудал дээр
д их бухимдалтай
д тавдугаар сарын
гаад зөвлөмж өгөх
эмж байсан. Ажил
р орчим болчих
арын хугацаанд
мжуулчихна шүү
замын газрын
д ч гэсэн иргэдийн

болж байна. Эсвэл шаардлага хангасан компанийг албаар унагах гэж янз бүрийн байдлаар оролдох асуудал ч багассан. Бусад тендер шалгаруулж байгаа газрууд ч гэсэн ил тод байх юм бол хардах сэрдэх асуудал байхгүй болно. Тендерийн шалгаруулалт хийж байгаа газрууд материалаа уламжлалт аргаар буюу цаасаар авч байна. Наад зах нь лац хэрэглэх хэрэгтэй байна. Тендерийн шалгаруулалтад өгсөн компанийн материал

... үнэлгээний хороо байгуулах эрхийг нь өгөхгүй байна. Хараат бус байдал гэсэн зарчим алдагдаад байна. Энэ алдааг засаад хуулийн дагуу яв гэдэг чиглэлийг гурван ч удаа өгчихсөн. Гэхдээ энэ одоо хүртэл хэрэгжихгүй л байна.

**-Тендерт шалгараагүй гэсээр болоод ажилд албаар саад хийх гэж хууль хяналтын байгууллагаар шалгуулж ажил хийлгэхгүй байгаа асуудал байдаг юм билээ. Энэ талаар?**


болон жижиглэнгийн худалдаа

- Рубероид
- Бикрост
- Биполь
- Линокром
- Унифлекс
- Техноэласт
- Стекломаст
- Атаклон
- Битум БН 90/10
- Праймер
- Мастика

МАНАЙ ХАЯГ:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 10-р хороолол, "Эрэл"-н 46-р байр/Төв замынхаа урд "Алейка"-ын рекламтай байр/, 9-р офис

Утас: 7000-6163, 89099998, 99735010
Факс: 7000-9801
Е-мэйл: burgedconstruction@gmail.com

тал болно

**МЕНЕЖЕР**

- Япон хэлний бичгийн болон ярианы ахисан түвшний мэдлэгтэй
- Бизнесийн удирдлага, худалдаа, маркетинг, хүнсний мэргэжлээр их, дээд сургууль төгссөн
- Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, санаачлах, үйл ажиллагааны талаар судалгаа хийх, дата мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх, мэдээлэл боловсруулах, тайлагнах чадвартай
- Компьютерийн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн

**Бүрдүүлэх материал:**

- Анкет (Компаний ажлын байранд ирж бөглөх)
- 3х4 хэмжээтэй цээж зураг 1%
- Боловсролын үнэмлэх, гэрчилгээ, дипломны хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар (Нотариатаар баталгаажсан)

Хаяг: БГД, V хороо, III эмнэлэгийн урд
"Техник Импорт" ХК
Утас: 7000 1830, 9508 4010, 9900 9445

"Эй Жи Зэт" ХХК

Danfoss

...и улсын
...oss компаний
...250-DN600
...тлэх ган
...мбөлгөн
...птандаа10%
...драл зарлаж
...а.

JIP BALL VALVES



...хугацаа 6-р сарын 1 нээс 7-р сарын 1 хүртэл
...3602, 99103602
...3604
...a.bold@agz.mn


GOBI

MONGOLIAN CASHMERE

"Говь" хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагт "Говь" ХК-ийн хурлын танхимд болно. Бүртгэх өдөр 2015 оны 2 дугаар сарын 28-ны өдөр. Хувьцаа эзэмшигч та бүхэн 5 дугаар сарын 23-ны өдрөөс брокер дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцана уу.

**ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

1. Компанийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдэд 09.30-17.00 цагийн хооронд "Говь" ХК-ийн төв байранд ирж Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргатай уулзан танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс харилцдаг брокер, диллерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер, диллерийн компанидаа эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2015 оны 6 сарын 22-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

**Холбоо барих утас:** 343051 (1226), 9811 8891
**И-мэйл:** tsaschikher@gobi.mn

**"Говь" ХК-ийн албан ёсны хаяг, байршил:**
Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг,
3-р хороо, Үйлдвэрийн гудамж, "Говь" ХК
**Утас:** 3413051, **Факс:** 343081